



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 27

№ 01/73 ДУА-2018/38/СОА-ТЦУЗ

Мандалговь хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 4,515,785.00 төгрөгийн дараах зөрчлүүд ирэлсэн байна. Үүнд:

1. Байгууллагын ахмадуудад нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас хүндэтгэл үзүүлж 1,362,385.00 төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, Сангийн сайдын 2014 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 55 дугаар тушаалын хавсралтын нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал хэсэгт /Хууль тогтоомжид заасны дагуу албан хаагчид нэг удаагийн тэтгэмж, буцалтгүй тусламж, шагнал, урамшуулал олгохтой холбоотой зардлыг энэ ангилалд бүртгэнэ/ заасныг зөрчсөн байна.

2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас үндэслэл буруу тушаалыг үндэслэн 2,123,400.00 төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно/ заасныг тус тус зөрчсөн байна.



3. Баталгаажуулаагүй тушаалаар гүйлгээ хийж, 1,030,000.00 төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5-д /Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно, Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна/ заасныг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны

өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.3-д /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар, батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн/, 4.1.7-д /Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Баталгаажуулаагүй, хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар гүйлгээ хийхгүй байх;
2. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;
3. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Төрийн аудитын газарт 2018 оны 03 дугаар сарын 25-ны дотор албан ёсоор ирүүлэхийг төсвийн шууд захирагч Ц.Мөнгөнцөөж, нягтлан бодогч Б.Сольхүү нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН!
АХЛАХ АУДИТОР  Т.БАТСАЙХАН ДАРГА
НЯГТЛАН БОДОГЧ  ЗӨВШӨӨРСӨН:
Ц.МӨНГӨНЦӨӨЖ
Б.СОЛЬХҮҮ
ЗКА0007 9034013

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.